



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/645

Булган сум

**Аймгийн Хөгжимт жүжгийн театрын  
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 5, 6, 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын сайдын 2025 оны 01/2515 дугаар чиглэлийн дагуу аймгийн Хөгжимт жүжгийн театрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллагсдын цалин хөлс, ажиллах орчин, нөхцөлийг батлагдсан төсвийн хүрээнд бүрдүүлж ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх), Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

4. Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/80 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010903

Аймгийн Засаг даргын 2025 оны  
 10 дугаар сарын 17-ны/ний өдрийн  
 А.1/645 дугаар захирамжийн хавсралт



**Аймгийн Хөгжимт жүжгийн театрын бүтэц орон тоо**

Д/д	Нэгж	Албан тушаал	Зэрэглэл ангилал	Орон тоо
1	2	3	4	5
1.	Захиргаа удирдлага	Дарга	ТҮСБ-6	1
		Нягтлан бодогч	ТҮМ-7	1
		Нярав	ТҮ-4	1
		Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан	ТҮ-7	1
		Маркетингийн менежер	ТҮСБ-4	1
2.	Үйлчилгээний анги	Зохион байгуулагч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	ТҮ-5	1
		Дууны инженер	ТҮСБ-3	1
		Гэрлийн техникч	ТҮСБ-3	1
		Лед дэлгэцийн ажилтан	ТҮСБ-3	1
		Тайзны эрхлэгч	ТҮСБ-3	1
		Хувцасны эрхлэгч	ТҮСБ-3	1
		Оёдолчин	ТҮСБ-3	1
		Жолооч, жижүүр	ТҮ-3	1
		Слесарь жижүүр	ТҮ-3	1
		Жижүүр	ТҮ-1	1
		Үйлчлэгч	ТҮ-1	2
3.	Уран бүтээлийн анги	Найруулагч	ТҮСБ-6	1
		Хор ангийн багш	ТҮСБ-5	1
		Хөгжим ангийн багш	ТҮСБ-5	1
		Бүжиг ангийн багш	ТҮСБ-5	1
		Дуучин	ТҮСБ-4	8
		Бүжигчин	ТҮСБ-4	8
		Хөгжимчин	ТҮСБ-4	9
		Жүжигчин	ТҮСБ-4	4
<b>Нийт</b>				<b>50</b>